БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: БӨА-2026/021/НА-СТА-ТШ3**

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2026 он


Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.com

Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Р.Баярмаа
Утас: 99265539 Цахим хаяг: bayarmaar@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт**

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫ ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2026.02.24 № 122

танай ____________-ны № ____________-т

БАЯННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
М.ЗАНГАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Баяннуур сумын Засаг даргын Тамгын газар 2025 онд 1,132.4 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 975.7 сая төгрөг зарцуулж, 86.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

8260500284

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **21,458,985.50** | **46,566,799.00** |
| **33** | **АВЛАГА** | 1,000,000.50 | 1,000,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,000,000.50 | 1,000,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 20,458,985.00 | 45,566,799.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 19,708,985.00 | 44,816,799.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 183,730.00 | 353,730.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 18,250,000.00 | 43,154,509.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,073,900.00 | 1,106,900.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 201,355.00 | 201,660.00 |
| 35600 | Мал амьтад | 750,000.00 | 750,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **820,043,175.86** | **1,354,643,627.75** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 820,043,175.86 | 1,354,643,627.75 |
| **392** | **Биет хөрөнгө** | 792,442,375.86 | 1,327,042,827.75 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 910,914,259.00 | 995,424,258.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (347,911,336.22) | (360,732,589.26) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 256,265,640.00 | 528,010,643.87 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (120,265,966.63) | (121,260,966.61) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 208,914,574.81 | 308,955,703.59 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (132,322,745.28) | (57,754,800.00) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 27,135,134.80 | 27,878,206.80 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (16,405,684.62) | (16,548,006.64) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 6,434,500.00 | 23,719,828.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (600,000.00) | (933,450.00) |
| 39217 | Ном | 284,000.00 | 284,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 27,600,800.00 | 27,600,800.00 |
| 39301 | Програм хангамж | 1,319,300.00 | 1,319,300.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (549,300.00) | (549,300.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 26,830,800.00 | 26,830,800.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **841,502,161.36** | **1,401,210,426.75** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **14,044,524.79** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 14,044,524.79 |
| **413** | **Өглөг** | - | 14,044,524.79 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 1,769,899.64 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 12,274,625.15 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 12,001,722.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 205,000.00 |
| 41364 | НДШ - ийн өглөг /ТӨҮГ/ | - | 67,903.15 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **841,502,161.36** | **1,387,165,901.96** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 841,502,161.36 | 1,387,165,901.96 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 409,753,076.00 | 409,753,076.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 51101 | Өмч: - төрийн | 409,753,076.00 | 409,753,076.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 287,015,073.58 | 839,445,071.18 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 287,015,073.58 | 293,781,330.58 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 545,663,740.60 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 144,734,011.78 | 137,967,754.78 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **841,502,161.36** | **1,401,210,426.75** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,103,720,987.81** | **1,620,067,692.13** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **182,550,401.81** | **587,213,448.65** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 182,550,401.81 | 587,213,448.65 |
| 120009 | Бусад орлого | 175,000.00 | 175,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 182,375,401.81 | 563,598,448.65 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | - | 23,440,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **921,170,586.00** | **1,032,854,243.48** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 26,470,586.00 | 19,422,939.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,000,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 22,470,586.00 | 19,422,939.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | - | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 894,700,000.00 | 1,013,431,304.48 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 894,700,000.00 | 1,013,431,304.48 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **928,594,323.00** | **1,074,403,951.53** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **928,594,323.00** | **1,074,403,951.53** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 906,458,144.57 | 989,456,632.88 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 661,756,816.50 | 758,221,941.49 |
| 210101 | Үндсэн цалин | 350,190,853.94 | 375,625,853.54 |
| 210102 | Нэмэгдэл | 292,327,400.00 | 381,781,462.95 |
| 210104 | Урамшуулал | 19,238,562.56 | 814,625.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 81,797,554.35 | 94,675,914.63 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 55,672,784.29 | 64,379,621.99 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,617,568.16 | 7,574,073.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,308,784.08 | 3,787,036.58 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,308,784.08 | 3,787,036.58 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,889,633.74 | 15,148,146.32 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 38,113,162.97 | 48,277,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,500,000.00 | 1,950,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 36,613,162.97 | 46,327,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 39,077,879.64 | 35,418,649.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,904,300.00 | 1,956,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 33,274,129.64 | 30,583,199.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,727,950.00 | 2,419,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 700,000.00 | 60,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 471,500.00 | 399,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 699,300.00 | 320,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 699,300.00 | 320,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,231,600.00 | 1,642,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 725,700.00 | 116,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 130,900.00 | 80,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,375,000.00 | 1,445,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,820,500.00 | 3,403,400.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,820,500.00 | 3,403,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,777,105.00 | 3,935,631.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,051,750.00 | 3,519,591.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 30,855.00 | 29,040.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 199,200.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 26,800.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 340,000.00 | 345,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 128,500.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | - | 42,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 69,184,226.11 | 43,561,296.76 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,663,000.00 | 8,990,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,012,000.00 | 244,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 50,509,226.11 | 34,326,996.76 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 22,136,178.43 | 84,947,318.65 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,701,108.00 | 34,987,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 18,624,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 16,701,108.00 | 16,363,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 5,435,070.43 | 49,960,318.65 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,435,070.43 | 49,960,318.65 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **175,126,664.81** | **545,663,740.60** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **175,126,664.81** | **545,663,740.60** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **921,345,586.00** | **1,033,029,243.48** |

| | | | |
|---|---|---|---|
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **175,000.00** | **175,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 175,000.00 | 175,000.00 |
| 120009 | Бусад орлого | 175,000.00 | 175,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **921,170,586.00** | **1,032,854,243.48** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 26,470,586.00 | 19,422,939.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,000,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 22,470,586.00 | 19,422,939.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 894,700,000.00 | 1,013,431,304.48 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 894,700,000.00 | 1,013,431,304.48 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **901,480,586.00** | **1,028,330,243.48** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **901,480,586.00** | **1,028,330,243.48** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **879,344,407.57** | **943,382,924.83** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 658,614,784.96 | 752,660,480.93 |
| 210101 | Үндсэн цалин | 351,188,866.40 | 372,567,817.11 |
| 210102 | Нэмэгдэл | 288,187,356.00 | 364,564,174.07 |
| 210104 | Урамшуулал | 19,238,562.56 | 15,528,489.75 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 83,247,300.00 | 98,399,571.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 56,608,700.00 | 67,841,771.90 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,659,100.00 | 7,640,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,329,900.00 | 3,819,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,329,900.00 | 3,819,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,319,700.00 | 15,278,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 42,940,262.97 | 48,277,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,500,000.00 | 1,950,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 41,440,262.97 | 46,327,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,041,887.17 | 20,618,323.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,877,300.00 | 1,664,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,265,137.17 | 15,579,432.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,727,950.00 | 2,419,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 700,000.00 | 468,391.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 471,500.00 | 486,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 699,300.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 699,300.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,231,600.00 | 2,429,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 725,700.00 | 321,400.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 130,900.00 | 158,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,375,000.00 | 1,950,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,820,500.00 | 3,403,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,820,500.00 | 3,403,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,065,195.00 | 3,524,849.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,339,840.00 | 3,004,209.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 30,855.00 | 29,040.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 199,200.00 | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 26,800.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 340,000.00 | 449,600.00 |
| 210807 | Газрын төлбөр | 128,500.00 | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | 42,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 46,683,577.47 | 14,069,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 45,671,577.47 | 13,825,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,012,000.00 | 244,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **22,136,178.43** | **84,947,318.65** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,701,108.00 | 34,987,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 18,624,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 16,701,108.00 | 16,363,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 5,435,070.43 | 49,960,318.65 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,435,070.43 | 49,960,318.65 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **19,865,000.00** | **4,699,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **19,865,000.00** | **4,699,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **19,865,000.00** | **4,699,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 19,865,000.00 | 4,699,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 19,865,000.00 | 4,699,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(19,865,000.00)** | **(4,699,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 409,753,076.00 | 144,734,011.78 | 287,015,073.58 | 841,502,161.36 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **409,753,076.00** | **144,734,011.78** | **287,015,073.58** | 841,502,161.36 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | 0.00 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **409,753,076.00** | **144,734,011.78** | **287,015,073.58** | 841,502,161.36 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **409,753,076.00** | **144,734,011.78** | **287,015,073.58** | 841,502,161.36 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 6,766,257.00 | 6,766,257.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **409,753,076.00** | **144,734,011.78** | **293,781,330.58** | 848,268,418.36 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | -6,766,257.00 | | -6,766,257.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 545,663,740.60 | 545,663,740.60 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **409,753,076.00** | **137,967,754.78** | **839,445,071.18** | 1,387,165,901.96 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,132,400,200.00** | **975,745,985.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,132,400,200.00 | 975,745,985.83 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,066,538,200.00 | 940,758,985.83 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 809,086,300.00 | 751,845,855.93 |
| 210101 | Үндсэн цалин | 383,084,400.00 | 372,567,817.11 |
| 210102 | Нэмэгдэл | 401,563,500.00 | 364,564,174.07 |
| 210104 | Урамшуулал | 24,438,400.00 | 14,713,864.75 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 102,437,000.00 | 98,305,889.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 69,657,100.00 | 67,748,089.90 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,195,000.00 | 7,640,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,097,500.00 | 3,819,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,097,500.00 | 3,819,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,389,900.00 | 15,278,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 48,360,600.00 | 48,277,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,950,000.00 | 1,950,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 46,410,600.00 | 46,327,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,845,000.00 | 14,618,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,262,500.00 | 1,664,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,197,500.00 | 9,464,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,100,000.00 | 2,419,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 700,000.00 | 583,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 585,000.00 | 486,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 778,500.00 | 194,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 778,500.00 | 194,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,011,700.00 | 2,809,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 621,700.00 | 451,400.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 190,000.00 | 158,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,200,000.00 | 2,200,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,847,500.00 | 3,403,400.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,847,500.00 | 3,403,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 21,627,700.00 | 5,234,540.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 19,304,000.00 | 4,375,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 503,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 184,800.00 | 29,040.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 392,000.00 | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 120,400.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 945,000.00 | 788,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 128,500.00 | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 50,000.00 | 42,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 59,543,900.00 | 16,069,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 59,012,900.00 | 15,825,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 531,000.00 | 244,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 65,862,000.00 | 34,987,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 65,862,000.00 | 34,987,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,624,000.00 | 18,624,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 47,238,000.00 | 16,363,000.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,132,400,200.00** | **975,745,985.83** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,132,400,200.00 | 975,570,985.83 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,132,400,200.00 | 975,570,985.83 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | 175,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 175,000.00 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 24.00 | 24.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 620001 | Удирдах ажилтан | 8.00 | 8.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 8.00 | 8.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 3.00 | 3.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **24.00** | **24.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9.00 | 9.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 5.00 | 5.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 3.00 | 3.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 7.00 | 7.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **25,763,586.00** | **7,322,939.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **25,763,586.00** | **7,322,939.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 25,763,586.00 | 7,322,939.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,134,000.00 | 814,625.00 |
| 210104 | Урамшуулал | 1,134,000.00 | 814,625.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | - | 93,682.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 93,682.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,388,586.00 | 6,114,632.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,388,586.00 | 6,114,632.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 990,500.00 | - |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 990,500.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 300,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 300,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,250,500.00 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,250,500.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 22,470,586.00 | 19,422,939.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 22,470,586.00 | 19,422,939.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 22,470,586.00 | 19,422,939.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баяннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын аудитор Р.Баярмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 3/11 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Баяннуур сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 928.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 13.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 44.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгав.

Тайлант онд  шилэн дансанд байршуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, аудитын тайлан, дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан 21.0 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний 2 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 31.4 сая төгрөгийн зарлагын 3 гүйлгээг  мэдээлээгүй, байгууллагын батлагдсан төсвийг хугацаа хоцроож байршуулсан байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 84.6 хувьтай, хугацаа хоцролтын хэрэгжилт 97.7 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор”, 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ....” , 6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Шилэн дансны цахим системд мэдээлээгүй 52.4 сая төгрөгийн 5 мэдэллийг нөхөж байршуулан зөрчлийг арилгах, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д заасан мэдээллийг бүрэн байршуулах, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх;

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Засаг даргын Тамгын газрын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн. Завсрын аудитаар нийт 20.5 сая төгрөгийн зөрчил илэрч, асуудлын бүртгэлээр танилцуулж, зөвлөмж өгсөн. Үүнд: байгууллагын хөрөнгийн түүвэрчилсэн тооллогыг хийхэд сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 16.0 сая төгрөгийн 1000 ширхэг боодол өвсийг хүлээн авсан боловч бүртгэлд тусгаагүй. Мөн бараа материалын тооллогоор 4.5 сая төгрөгийн 300 ширхэг боодол өвс илүү гарсан ба энэ нь тайлант хугацаанд 500 ширхэг боодол өвс хүлээн авч, 200 ширхэг боодол өвсний зарцуулалтыг бүртгээгүй байсантай холбоотой байна. Дээрх өвсийг бүртгэлд тайланд тусгах талаар зөвлөмж өгснийг санхүүгийн тайлангийн аудитаар хэрэгжилтийг шалгахад нярав болон нягтлан бодогч нар тооцоо нийлж зарцуулалтыг бүртгээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам зөрчсөн 127.9 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгөгдсөн ба давтан шалгаж үзэхэд хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | Биелэлт |
|---|---|---|

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 3 | 127,856.2 | 3 | 127,856.2 | 100 |
| **Нийт дүн** | 3 | 127,856.2 | 3 | 127,856.2 | 100 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 56.9 сая төгрөгийн алдаа илэрч аудитын явцад залруууллаа. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсөвт санхүүжүүлэх эх үүсвэрийг 13.5 сая төгрөгөөр дутуу, зардалд 5.5 сая төгрөгөөр илүү, гүйцэтгэлд санхүүжүүлэх эх үүсвэр хэсэгт төвлөрүүлсэн 37.9 сая төгрөгийг цэвэрлээгүй тайлагнасныг залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар 87.8 сая төгрөгийн зөрчил илэрч 2 зөвлөмж өгөв.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр албан шаардлага өгөгдөөгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Бараа материалын данстай холбоотой асуудал

<u>1.1.Илрүүлэлт:</u>

Жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийсэн боловч бараа материалын тооллогын бүртгэлийн баримтжуулалт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2- “хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-т “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>1.2 Өгсөн зөвлөмж</u>*:

Бараа материалын тооллогын бүртгэлийг бүрэн хөтөлж баталгаажуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

### 2.Анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт:

Нярвын тайлангаар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 32.2 сая төгрөгийн 960 уут (нэг бүр нь 34.5 мянган төгрөгийн үнэтэй) хивэг орлогод авч зарлага гаргасан боловч санхүүгийн тайлан, журналд оны эхэнд 18.2 сая төгрөгийн 529 уут хивэг үлдэгдэлтэй ба орлого, зарлага бүртгэгдээгүй байна. Сумын Онцгой комиссын хурлаар комиссын гишүүдийн олонхын саналаар дээрх 960 уут хивгийг нэг бүрийг нь 20.0 мянган төгрөгөөр малчдад борлуулахаар шийдвэрлэсний дагуу нярав нь хивгийг борлуулж орлогыг бүрэн төвлөрүүлсэн гэх боловч нэмэлт санхүүжилтийн дансанд 11.8 сая төгрөг, сумын ОНХС-ийн дансанд 6.6 сая төгрөг, нийт 18.4 сая төгрөгийг төвлөрүүлж, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Малчдад хэдэн төгрөгийн хэдэн уут хивэг хэнд тараасан, хэдэн уут хивэг үлдсэн, төлбөрийг барагдуулсан эсэх талаар тооцоо хийж тайлагнаагүй, анхан шатны баримт хангалтгүй, эмх цэгцгүй жагсаалт хавсаргасан байна.

Мөн нярвын тайлангаар нэг бүр нь 15.9 мянган төгрөгийн 200 боодол 3,188.0 мянган төгрөгийн өвсийг жагсаалтаар борлуулсан гэх боловч санхүүгийн тайлан тодруулга, журналд зарлагад бүртгэгдээгүй, борлуулсан өвсний тооцоог хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-т “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалттай нийцэхгүй байна.

*2.2. Өгсөн зөвлөмж*:

Өвс, тэжээлийн орлого, зарлагын бүртгэлийг бүрэн хөтлөх, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, анхан шатны баримтыг бүрдүүлэлтийг хангаж зөрчлийг арилгах, хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч **хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** аудитын тайланг хүлээн авснаас хойш **30 хоногийн дотор, з**өвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй тайлагнасан. | 1 | 56,860.3 | | | 1 | 56,860.3 | 1 | 56,860.3 | | | | |
| **Дүн** | 1 | 56,860.3 | | | 1 | 56,860.3 | 1 | 56,860.3 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс |
|---|---|---|

| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бараа материалын тооллогын бүртгэлийн баримтжуулалт хангалтгүй. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Өвс, тэжээлийн бүртгэл тооцоотой холбоотой | 1 | 35,408.0 | | | | | 1 | 35,408.0 | | | | |
| **Дүн** | 2 | **35,408.0** | | | | | 2 | **35,408.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсан мэдээлээгүй орхигдуулсан | 1 | 52,421.6 | | | | | 1 | 52,421.6 |
| **Дүн** | **1** | **52,421.6** | | | | | **1** | **52,421.6** |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **52,421.6** | | | | | **1** | **52,421.6** |